



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (367)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2004 оны есдүгээр сарын 6

№34 (367)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

349.	Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай	Дугаар 06	690
350.	Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай	Дугаар 07	690
351.	Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай	Дугаар 08	690
352.	Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 09	691
353.	Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай	Дугаар 10	691

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

354.	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 156	691
------	--	------------	-----



2004 оны 8 дугаар  
сарын 19-ний өдөр

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин  
деревдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын  
Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь  
хэсгийн 2 дахь заалт, 27 дугаар зүйлийн 1 дэх  
хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол  
Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын дэд даргаар  
Улсын Их Хурлын гишүүн Данзангийн Лүндээжанцанг  
сонгосуяй.

2. Энэ тогтоолыг 2004 оны 8 дугаар сарын  
19-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

2004 оны 8 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

### Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28  
дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын  
чуулганы хуралдааны дэгийн 3.3 дахь заалт, санал  
хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их  
Хурлаас ТОГТООХ нь:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын  
байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн  
Мэндсайханы Энхсайхан, Байгаль орчин, хөдөөгийн  
хөгжлийн байнгын хорооны даргаар Улсын Их  
Хурлын гишүүн Чойжамцын Раднаа, Нийгмийн  
бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их  
Хурлын гишүүн Самбуугийн Ламбаа, Төрийн  
байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их  
Хурлын гишүүн Сундуйн Батболд, Төсвийн байнгын

хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн  
Рагчаагийн Бадамдамдин, Хууль зүйн байнгын  
хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн  
Доржийн Одбаяр, Эдийн засгийн байнгын хорооны  
даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэндэшийн  
Дамиран нарыг тус тус сонгосуяй.

2. Энэ тогтоолыг 2004 оны 8 дугаар сарын  
19-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

2004 оны 8 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин  
тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, Монгол Улсын  
Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь  
хэсгийн 4 дэх заалт, санал хураалтын дүнг үндэслэн  
Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар  
Цахиагийн Элбэгдоржийг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2004 оны 8 дугаар сарын  
20-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР



2004 оны 8 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар  
хот

## Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Улсын Их Хурал дахь МАХНын бүлгийн дүгнэлтийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүдийн саналыг харгалзан Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатарыг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төсвийн байнгын

хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүү Н.Энхбаярыг Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай

2. Энэ тогтоолыг 2004 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрднө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.ЭНХБАЯА**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 8 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

## Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

### 1/Ес зүйн дэд хороо:

1. Горчинсүрэнгийн Адъяа
2. Сангажавын Баярцогт
3. Лувсаннямын Гантемэр
4. Дүрзээгийн Одхүү
5. Аюурзанын Цанжид

### 2/Нутгийн өөрөө удирдах ёсны дэд хороо:

1. Цэвэлмаагийн Баярсайхан
2. Рэнцэнгийн Буд
3. Долцонгийн Дондог
4. Дамдины Дэмбэрэл
5. Аукетайн Мурат
6. Мишигийн Сономпил

### 3/Төсвийн зарлагын хяналтын дэд хороо:

1. Тунжингийн Бадамжунаай
2. Агыпарын Бакей
3. Гомбожавын Занданшатар
4. Мөнхчулгуны Зоригт
5. Жанлавын Наранцацрагт
6. Лханаасурэнгийн Пүрэвдорж

### 4/Хүний эрхийн дэд хороо:

1. Батын Батбаатар
2. Цэрэнгийн Жаргал
3. Цэндийн Мэнх-Оргил
4. Рэгжийбууний Нямсүрэн

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 7 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар  
хот

## Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

2004-2005 оны мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/мал сүргийг оторлон таргалуулах, аймаг сумын нөөцед хүрэлцэхүйц хэмжээний ёвс, тэжээ. бэлтгүүлэн нөөцлөн малыг эрсдэл багатаа өвөлжүүлж, хаваржуулах зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй;



б/малчин өрх бүрээр өвс, тэжээл, элолцоотой бүх төрлийн гар тэжээл бэлтгүүлэх, эшээ хороо, уст цэгийг засварлах ажилд мальчид, эгэд, аж ахуйн нэгжийн хувийг чиглүүлэх 2 сарын эхистой ажлыг 8 дугаар сарын 1-нээс эхлэн зохион айгуулсугай;

в/бэлчээрийн гарц, усан хангамж, газар угтыйн онцлогийг харгалзан мал оторлох бус угтыйн оновчтой сонгон отрын түр штаб байгуулж, үн, мал эмнэлэг, хүнс, ергэн хэрэглээний баараны үйлчилгээний цэгийг ажиллуулах, отроор вэлжүүлэх өрх, малын тоог тогтоосугай;

г/аймаг, сумын удирдлага харилцан гэрээ ийсний үндсэн дээр мал оторлон өвөлжүүлэх, лангуга адууг алсын оторт гаргах арга хэмжээ авч эрэгжүүлсүгэй;

д/гар худаг гаргах, өтөг бууцыг ариутган алдвартайтуулж, мал тэжээж арчлах, сувилан энхруүлэх арга ажиллагаанд малчдыг сургах арга эмжээ авч ажилласугай;

е/мал сүргийг эрүүлжүүлэх, заазлаж ялгах юлон мал бэлтгэл, бог малын хээлтүүлэг зэрэг цаг үеийн ажлыг зохих хугацаанд нь явуулахад тэргэжлийн байгууллагын дэмжэлг, туслацааг илгүүлж ажилласугай.

2. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д. Насанжаргалд даалгах нь:

а/малчдын хүчээр гар худаг гаргах, хадлан, тэжээл бэлтгэх болзоолт уралдааныг улсын эмийн зарлан дүгнэх урамшуулан амжилтыг нь чийтэд сурталчлах арга хэмжээг авсугай;

б/мал, мал бэлтгүүлж зах зээлд нийлүүлэх замаар Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон хот суурин газрын 2005 оны махны хангамжийг хэвийн байлгах, махны экспортыг нэмэгдүүлэх ажилд бодит дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажилласугай;

в/улсын нөөцийн өвс, тэжээлийн цэг, салбарын агуулах, саравчны засварын ажлыг шуурхай авч хэрэгжүүлэх, салбарын агуулах, саравчны засварын ажлыг шуурхай авч хэрэгжүүлэх, цагийн хийдээр 8 дугаар сарын 15-ны дотор барагдуулахыг Баян-Өлгий аймгийн Засаг дарга Х.Бадэлхан, Ховд аймгийн Засаг дарга Д.Галсандонг, Увс аймгийн Засаг дарга Л.Тогоо нарт тус тус даалгасугай.

г/энэхүү тогтооолын биелэлтэд байнга хяналт гавин зохицуулалт хийж, мал өвөлжилтийн бэлтгэл ажлын дүнг нэгтгэн 2004 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулсугай.

3. Түлш, эрчим хүчний хангамж, зам, тэзвэр, харилцаа холбоо, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, хугацаанд нь хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жижидэд даалгасугай.

4. Улсын нөөцийн орон нутаг дахь өвс, тэжээлийн цэг, салбарын агуулах, саравчны засварын ажлыг шуурхай дуусган, нөөцийн өвс, тэжээлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй аймгийн улсын нөөцийн цэг, салбарт байх өвс, тэжээлийн тоо хэмжээг нэмэгдүүлж, оновчтой байршуулах ажлыг 11 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Гамшигаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Дашид үүрэг болгасугай.

5. Мал өвөлжүүлж, хаваржуулах зохион байгуулалтыг шуурхай авч хэрэгжүүлэх, цагийн хийдээр 8 дугаар сарын 15-ны дотор барагдуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Гамшигаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Даш нарт даалгасугай.

6. Тусгай хамгаалалтын болон хилийн зурvas газарт мал оторлон өвөлжүүлэх асуудлыг судалж зохицуулалт хийхийг Байгаль орчны сайд У. Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц. Нямдорж нарт даалгасугай.

7. Хүйтний улирлын цаг агаарын тойм болон цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллийг сар, арав хоногор гаргаж малчид, иргэдэд урьдчилан сэргэжилүүлэх, мэдээ мэдээлээр тогтол хангаж ажиллахыг Байгаль орчны сайд У. Барсболдод даалгасугай.

8. "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-иас цахилгаан эрчим хүч авч хэрэглэсэн өрийг 8 дугаар сарын 15-ны дотор барагдуулахыг Баян-Өлгий аймгийн Засаг дарга Х.Бадэлхан, Ховд аймгийн Засаг дарга Д.Галсандонг, Увс аймгийн Засаг дарга Л.Тогоо нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
САЙД** **Д.НАСАНЖАРГАЛ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар- 12,

Төрийн ордон

329612

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

№ 329487

Хэвлэлийн хуудас 0.5